

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд
хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2024/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

БУЛГАН АЙМГИЙН ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.ТӨГСБАЯР ТАНАА

2024.02.23 № 89

танай _____ ны № _____ т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Булган аймагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт баривчлагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдүүдэд зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж авахад 10,000.0 мянган төгрөгийг дэмжлэг үзүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь “Даталанд технологи” ХХК-тай гэрээ байгуулж “Төсвийн нэгдсэн систем” программыг 4,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан.

006020199

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд цалингийн сангийн хэмнэгдсэн төсвөөс Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтын дагуу 10,354.6 мянган төгрөгийн ахмадын санд төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	70507086.46	80815309.31
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1270836934.20	1227388802.27
Нийт хөрөнгийн дүн	1341344020.66	1308204111.58
Нийт өр төлбөрийн дүн	0.00	5654832.19
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1341344020.66	1302549279.39
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1341344020.66	1308204111.58
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	745851233.01	1020028885.96
Үйл ажиллагааны зардлын дүн	741133503.65	1058823627.23
Үйл ажиллагааны үр дүн	4717729.36	-38794741.27
Үйл ажиллагааны бус үр дүн		87021.01
Үйл ажиллагааны нийт үр дүн	4717729.36	-38794741.27
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,072,727.16	1,341,344,020.66
Тайлант оны үр дүн		-38,794,741.27
Эцсийн үлдэгдэл	337,072,727.16	1,302,549,279.39
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	705144230.25	1026127723.09
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	705414430.25	1016039089.69
Үйл ажиллагааны ЦМГ	-270200.00	10088633.40
Хөрөнгө оруулалтын ЦМГ		
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-270200.00	10088633.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		346,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,434,633.40
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1015952068.68
Урсгал зардал		1015952068.68
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих		972796131.32
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		34810621.01

Гурав.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,967.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 312.9 мянган төгрөгийн 1 алдаа, 5,654.8 мянган төгрөгийн 1 зөрчил илэрч зөвлөмж өглөө.

1. Хоол хүнсний зардлын 312.9 мянган төгрөгийг зөрүүтэй тусгасныг засаж тусгуулсан.

3.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

3.2 Албан шаардлага бичигдээгүй

3.3 Зөвлөмж

1. "Булган Мээж" ХХК-д жилийн эцэст түлш халаалтын зардал дээр 5.5 сая төгрөгийн алданги тооцогдсон, хувь хүнд 50.0 мянга, хоригдолд өгөх 30.0 мянган төгрөгийн өглөг үүссэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дах "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	1	0.3			1	0.3	1	0.3				
Дүн	1	0.3			1	0.3	1	0.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	1	5.6					1	5.6				
Дүн	1	5.6					1	5.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						